



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/401

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх зорилт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн "Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай" 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хүрээнд Чандмань сумын Хүрхрээ багт хүлэмж нийлүүлэх ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг сумын Засаг дарга (Ч.Эрдэнэ-Очир)-д олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Ч.Эрдэнэ-Очир)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:/My documents/-3A-4 doc

0201001285